


RICHWELL
ENGINEERING LLC

# РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ

Rich in know how, rich in success

RICHWELL
ENGINEERING LLC

## АЛСЫН ХАРАА

Бид орчин үеийн инженерингийн баялаг мэдлэг, чадвар хуримтлуулж Монгол хүний сайн сайхан ирээдүйн төлөө тэмүүлнэ.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид Инженерийн иж бүрэн шийдлээр хангаж үнэ цэнийг бий болгоно.

# РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ

Бид инженерийн иж бүрэн шийдлээр хангаж үнэ цэнийг бий болгоно




## БИДНИЙ ТУХАЙ

"Ричвелл Инженеринг" ХХК нь 2012 оноос хойш Эрчим хүч, дэд бүтэц, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт зураг төсөл, төсөв боловсруулах, барилга, эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцын угсралт, материал тоног төхөөрөмж нийлүүлэлт, төслийн удирдлагын менежмент болон бусад инженерингийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн тасралтгүй идэвхитэй бизнесийн үйл ажиллагаагаа эрхэлж байна.

Бид  чадварлаг туршлагатай 100 гаруй инженер техникийн ажилтнуудтай хүчирхэг багийг бүрдүүлэн, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглан инженерингийн иж бүрэн шийдлээр хангаж Монгол улсынхаа хөгжил дэвшил, эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтад өөрсдийн бодитой хувь нэмрийг оруулж,  үнэ цэнийг бий болгохыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

"Ричвелл Инженеринг" ХХК нь олон улсын нэр хүндтэй түншүүдтэй хамтран ажиллаж, дэлхийн шилдэг туршлагыг төсөл бүрт нэвтрүүлж, ногоон инженерчлэл, инноваци, BIM технологийн нарийвчлалыг ашиглаж төслийн аюулгүй, ашигт ажиллагааг хангах найдвартай түнш юм.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

# ЧИГЛЭЛ



**ЗУРАГ ТӨСӨЛ**



**ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА УГСРАЛТ**



**РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТЖУУЛАЛТ**

Бид орчин үеийн инженерийн баялаг мэдлэг, чадвар хуримтлуулж түүгээрээ Монгол хүний сайн сайхан ирээдүйг бүтээхийн төлөө тэмүүлнэ.



RICHWELL
ENGINEERING LLC

Rich in know how, rich in success



- Эрчим хүчний эх үүсвэр болон инженерийн шугам сүлжээний ТЭЗҮ ажлын зураг
- 0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабел шугам, дэд станцын угсралт
- Цахилгаан цэнэгт хуримтлуурын систем, реактив чадлын компенсаторийн шийдэл
- Иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн иж бүрэн ажлын зураг
- Реле хамгаалалт автоматжуулалт болон үйлдвэрийн процессын автоматжуулалтын угсралт, туршилт тохируулга
- Гадаадын туршлагатай компаниудтай хамтран орчин үеийн стандартад нийцсэн шийдэл боловсруулах, зураг төслийн орчуулгыг өндөр түвшинд гүйцэтгэнэ




# ЗУРАГ ТӨСӨЛ

RICHWELL
ENGINEERING LLC

Ричвелл Инженеринг ХХК-н Инженеринг зураг төслийн газар нь компани үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Эрчим хүчний эх үүсвэр, дулаан болон цахилгаан хангамжийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил үйлчилгээ үзүүлсээр байна.

Зураг төслийн газар нь олон жилийн туршлагатай мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудын ур чадвар дээр үндэслэн орчин үеийн шинэ техник технологийг ашигласан инженерингийн цогц шийдлээр,барилга байгууламж, ерөнхий төлөвлөгөө болон инженерингийн иж бүрэн ажлын зураг төсөл, зохиогчийн хяналт, ТЭЗҮ боловсруулах ажил гүйцэтгэх, хүлээлгэн өгөх гэсэн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.



Дэд бүтцийн шугам
сүлжээний ажлын зураг төсөл

Дулаан, цахилгааны эх үүсвэрийн
ажлын зураг төсөл, ТЭЗҮ

Хот төлөвлөлт, барилга байгууламж,
ерөнхий төлөвлөгөөний ажлын
зураг төсөл

Зураг төслийн зохиогчийн хяналт

Иргэний ба үйлдвэрийн барилга
байгууламжийн ажлын зураг төсөл

Реле хамгаалалт,автоматик, үйлдвэрийн
автоматжуулалтын зураг төсөл



RICHWELL
ENGINEERING LLC

# ЗУРАГ ТӨСЛИЙН ТӨСЛҮҮД

**Төслийн нэр:**
Дэнжийн мянга дэд төвд баригдах 80 Гкал/цаг хүчин чадалтай оргил ачааллын хийн дулааны эх үүсвэрийн зураг төсөл

**Захиалагч:** Азийн хөгжлийн банк

**Төслийн товч танилцуулга:**
Өндөр хүчин чадлын Дулаан хуваарилах төв барьж, Дэнжийн мянга дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох, Оргил ачааллын үеийн хийн түлштэй дулааны бие даасан дулааны эх үүсвэрийг төвлөрсөн сүлжээтэй хослуулан ажиллуулах

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
Шинээр төлөвлөж буй Дэнжийн мянга дэд төвийн 80ГКал/ц хүчин чадалтай хийн дулааны станцын иж бүрэн ажлын зураг төсөл хийсэн.






**Төслийн нэр:**
Дархан хотын Хоккейн ордны барилга

**Захиалагч:** Барилга хот байгуулалтын яам

**Төслийн товч танилцуулга:**
764 хүний суудалтай Өвлийн спорт ордон /Хоккейн ордон/, өвөл зуны туршид ажиллах мөсөн талбай бүхий спорткомплексийн зураг төсөл.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
Дархан хотын Хоккейн ордны барилгыг очин үеийн өнгө төрх бүхий эрчим хүчний хэмнэлттэй хөргөлтийн тоног төхөөрж бүхий шийдлээр олон улсын стандартад нийцсэн мөсөн талбай бүхий спорткомплексийн иж бүрэн зураг төсөл боловсруулсан.

**Төслийн нэр:**
Морингийн даваа орчмын "ЗАЛУУС-1" орон сууцны төслийн хүрээнд хийгдэж буй дулааны станцын зураг төсөл

**Захиалагч:** Барилга хот байгуулалтын яам

**Төслийн товч танилцуулга:**
Морингийн даваа орчмын хэрэглэгчдийг төвийн дулаан хангамжийн системээс хамааралгүй өөрийн бие даасан дулааны эх үүсвэрээр хангах 100МВт хүчин чадалтай дулааны станцын зураг төсөл.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
100МВт хүчин чадалтай иж бүрэн дулааны станцын зураг төсөл гүйцэтгэсэн





**Төслийн нэр:** Урбан плаза

**Захиалагч:** Азийн хөгжлийн банк

**Төслийн товч танилцуулга:**
Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны газар нутагт Баянхошуу дэд төв-д хамаарагдах 1,3 га талбайд Урбан плаза тохижилтын зураг төсөл.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
Ногоон байгууламж, хөшөө, монументал, мөн нийтийн бие засах газартай олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, чөлөөт цагаа өнгөрөөхөд таатай орчин бүрдүүлэх 1,3 га талбайн тохижилтын зураг төсөл.

**Төслийн нэр:**
110/10кВ-н дэд станц, Агаарын шугамын зураг төсөл

**Захиалагч:**
“Наанова грийн энержи Монголиа” ХХК

**Төслийн товч танилцуулга:**
Хог шатаах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах 110/10кВ-н дэд станц болон Агаарын шугамын зураг төсөл.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
• Буянт-Ухаа дэд станцыг 110 кВ-н ил хуваарилах байгууламжийг 2 гаргалгаагаар өргөтгөх,
• 110кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын 8,6 км шугам,
• 110/10кВ-ын 2х16МВА чадалтай дэд станцын ажлын зургууд.





**Төслийн нэр:**
Мобикомын холбооны станц дээр нарны зайн цахилгаан системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилалтын ажлын зураг

**Захиалагч:** “Мобиком корпораци” ХХК

**Төслийн товч танилцуулга:**
Алсын зайн мэдээлэл дамжуулах станцын байнгын тогтвортой үйл ажиллагааг хангах 445Вт чадалтай 34 ширхэг нарны монополяр толь бүхий цэнэг хураах станций зураг төсөл

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
• Тооцоо судалгаа
• Сэргээгдэх эрчим хүчий эх үүсвэрийн иж бүрэн зураг төсөл

**Төслийн нэр:**
Шархад дэд төвийн дэд бүтцийн зураг төсөл

**Захиалагч:**
Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

**Төслийн товч танилцуулга:**
Нийслэлийн Баянгзүрх дүүргийн 89,10,17,19,24-р дүүргүүдийн нутаг дэвсгэрт (250 га) газарт дэд бүтцийн иж бүрэн зураг төсөл.



**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**

- Авто замын 7.7 км иж бүрэн ажлын зураг
- Үерийн суваг 0.73 км иж бүрэн зураг төсөл
- Хөв цөөрөм 1 ширхэг иж бүрэн зураг төсөл
- Замын борооны усны шугам 19 км иж бүрэн зураг төсөл
- Цэвэр усны шугам ф150мм-300мм 9.2 км иж бүрэн зураг төсөл
- Бохир усны шугам, ф200-300 4.4 км иж бүрэн зураг төсөл
- Насос станц (Q=4600м3/ц) 1 ширхэг иж бүрэн зураг төсөл
- Усан сан 1000м3 2 ширхэг иж бүрэн зураг төсөл
- Дулаан шугам, Dх200-600мм 6.5 км иж бүрэн зураг төсөл
- УДДТ 9 ширхэг иж бүрэн зураг төсөл
- Шилэн кабел 10 км иж бүрэн зураг төсөл
- Сувагчлал (4+0) 110mm 16 км иж бүрэн зураг төсөл
- Дата төв 1 ширхэг иж бүрэн зураг төсөл
- Цамхаг 25-30м 1 ширхэг иж бүрэн зураг төсөл
- 10кВ Цахилгаан шугам 24.6 км иж бүрэн зураг төсөл
- 10 кВ РП /Хуваарилах байгууламж 2 ширхэг иж бүрэн зураг төсөл
- 10/0.4 кВ ХТП/ Хаалттай дэд станц 7 ширхэг иж бүрэн зураг төсөл



**Төслийн нэр:**
Ханбогд дулааны станцын ТЭЗҮ, дулааны станц, шугам сүлжээний зураг төсөл.

**Захиалагч:**
Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар

**Төслийн товч танилцуулга:**
Ханбогд сумын төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээ, 15МВт Дулааны станцын ТЭЗҮ, иж бүрэн зураг төсөл.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- 5МВт хүчин чадал бүхий дулааны станцын ТЭЗҮ
- 5МВт хүчин чадал бүхий дулааны станцын иж бүрэн зураг төсөл
- 26км дулааны шугам сүлжээний иж бүрэн зураг төсөл
- УДДТ 9 ширхэг иж бүрэн зураг төсөл



**Төслийн нэр:**
Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2-р хэлхээний шугам сүлжээ, хэрэгцээний халуун ус төлөвлөх, УДДТ-үүдийн гадна инженерийн шугам сүлжээ төлөвлөх зураг төсөл

**Захиалагч:**
Баянхонгор аймгийн засаг даргын тамгын газар

**Төслийн товч танилцуулга:**
10 аймгийн төвийн дулааны станц барих төслийн хүрээнд уг төсөл хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрийн гол зорилго нь найдвартай дулааны эх үүсвэр бий болгож, иргэдийг жилийн турш халаалт, хэрэгцээний халуун усаар тасралтгүй хангах, агаарын бохирдлыг бууруулах юм.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- Дулааны станцын барилгын гадна холбоо, цэвэр усан хангамж, ариутгах татуургын ажлын зураг
- Дулааны станцын 8ш УДДТ-ийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв



# ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА УГСРАЛТ



RICHWELL
ENGINEERING LLC

Бид 2012 оноос эхлэн Эрчим хүчний барилга угсралт бүтээн байгуулалтын чиглэлээр 0,4-110кВ-ын ЦДАШ, дэд станцууд, дулааны станц, зуух, дулааны шугам сүлжээ, үйлдвэрийн автоматжуулалтын систем зэрэг томоохон төслүүдийн барилга угсралтыг амжилттай гүйцэтгэж байна.

Ричвелл Инженеринг ХХК нь жилдээ 150 км урт ЦДАШ барьж байгуулах, 10-80 МВА чадалтай 4 дэд станц барьж байгуулах, зуух, зуухны автоматжуулалт, 16-40кгх/ см2 даралттай дулааны шугам сүлжээ, ЦТП-ний барилга угрсалтыг хийх хүчин чадал, нөөцтэй.

Rich in know how, rich in success




- Цахилгаан эрчим хүч дамжуулах болон түгээх шугам сүлжээ, дэд станц
- Барилга угсралтын төслийн удирдлага
- Дулааны станц, дулааны шугам сүлжээ, эрчим хүчний байгууламжийн угсралт
- Барилга угсралтын ажлын төлөвлөлт, хяналт
- Үйлдвэрийн процессийн автоматжуулалт
- Барилга угсралтын ажлын чанрын хяналт
- Барилга угсралтын бичиг баримт бүрдүүлэлт
- Зуухны автоматжуулалтын системийн угсралт

RICHWELL
ENGINEERING LLC



# БАРИЛГА УГСРАЛТЫН ТӨСЛҮҮД




**Төслийн нэр:**
Түлхүүр гардуулах нөхцөлтэй Статик Вар Генератор төхөөрөмжийн ажил

**Захиалагч:**
Азийн хөгжлийн банк болон Эрчим хүчний яам

**Төслийн товч танилцуулга:**
Завхан аймгийн 110/35/10кВ-ын “Тэлмэн” дэд станцын 110кВ
ын ситем шинд 10МВар SVG төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт болон туршилт тохируулга хийх

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**

- 110кВ-ын систем шинд 10МВАр чадалтай хүчдэл тохируулгын SVG төхөөрөмжийг суурилуулах
- 16МВА чадалтай хүчний трансформатор угсарч суурилуулах
- Хүчний трансформатор болон SVG төхөөрөмжийн реле хамгаалалтын туршилт, тохируулга хийх

**Төслийн нэр:**
"Говьсүмбэр аймаг" СанСтеппе ХХК-ын 50МВт чадалтай нарны цахилгаан станц, 110 кВ-ын ЦДАШ, 110/35кВ-ын 2*30 МВА чадалтай дэд станцын барилга угсралтын ажил

**Захиалагч:** СанСтеппе ХХК

**Төслийн товч танилцуулга:**
Говьсүмбэр аймгийн Чойр хотод хийгдэж буй нарны цахилгаан станц нь өөрийн салбарт дэвшилтэд шинэ техник, технологийг нэвтрүүлж олон улсын чанарын болон аюулгүй ажиллагааны өндөр стандартуудад нийцүүлэн хэрэгжүүлсэн төсөл юм.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- 50МВт чадалтай нарны цахилгаан станцын угсралт
- 110кВ-ын ЦДАШ угсралт
- 110/35кВ-ын 2*30 МВА чадалтай дэд станцын угсралт
- 35кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн угсралт





**Төслийн нэр:**
"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөлийн гадна цахилгаан хангамжийн хүрээнд 110кВ-ын систем шинд 15Мвар хүчин чадалтай хүчдэл тохируулгын SVG тоног төхөөрөмж, ИХБ-110кВ өргөтгөлийн тоноглол суурилуулах ажил

**Захиалагч:** "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ

**Төслийн товч танилцуулга:**
Өвөрхангай аймгийн 110/35/10кВ-ын "Хархорин" дэд станцын 110кВ-ын систем шиний өргөтгөл болон 110кВ-ын ситем шинд 15МВар SVG төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт болон туршилт тохируулга хийх

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- 110кВ-ын систем шинд 15МВАр чадалтай хүчдэл тохируулгын SVG төхөөрөмжийг суурилуулах
- 110кВ-ын систем шиний өргөтгөл хийх
- 16МВА чадалтай хүчний трансформатор угсарч суурилуулах
- Хүчний трансформатор болон SVG төхөөрөмжийн реле хамгаалалтын угсралт

**Төслийн нэр:**
Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт 2х40 МВА чадалтай 110/10 кВ-ын Хүчит Шонхор дэд станцын барилга угсралтын ажил

**Захиалагч:** Эрчим хүчний яам, ЦДҮС ТӨХК

**Төслийн товч танилцуулга:**
Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Чингэлтэй дүүргийн дэнжийн мянгын орчмын айл өрхийн цахилгаан халаагуур хэрэглэх техникийн боломжийг бүрдүүлэх зорилгоор уг төслийг хэрэгжүүлэв

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
2х40 МВА чадалтай 110/10 кВ-ын дэд станц, удирдлагын байр, 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, реле хамгаалалтын туршилт, тохируулгын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр хийж гүйцэтгэсэн.





**Төслийн нэр:**
Орхон аймгийн Баян-Өндөр сумын 6/0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил

**Захиалагч:** Эрчим хүчний төсөл-2

**Төслийн товч танилцуулга:**
Дэлхийн банкны санхүүжилтээр эрчим хүчний төсөл-2-ын хүрээнд уг төслийг хийж гүйцэтгэв

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
8971 ш төмөр бетон шон, 268 км СИП-2А дамжуулагч утас, 14484 ш гэр хорооллын айл өрхийн ухаалаг тоолуур, 877 ш ААН-ийн ухаалаг тоолуур, 9 ш агаарын шинэ дэд өртөө, 60 ш орон сууцны цахилгаан хангамжийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Төслийн нэр:**
Төв аймаг Сэргэлэн сум Хөшгийн хөндий дэх "Аэросити" шинэ хотын цахилгаан хангамжийн 220/110/35кВ-ын 2*125МВА чадалтай Сэргэлэн дэд станц

**Захиалагч:** Эрчим хүчний яам

**Төслийн товч танилцуулга:**
Төв аймаг Сэргэлэн сум Хөшгийн хөндий дэх "Аэросити" шинэ хотын цахилгаан хангамжийн 220/110/35кВ-ын 2*125МВА чадалтай Сэргэлэн дэд станцын барилга угсралт, туршилт тохируулгын ажил хийх

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- 220/110/35кВ-ын ил хуваарилах байгууламжийн тоноглолуудыг угсрах, туршилт тохируулга хийх
- Реле хамгаалалтын иж бүрэн холболт, тоноглол суурилуулалт, туршилт тохируулгын ажил
- Дэд станцын зам талбай, үерийн далан хийх
- Дэд станцын удирдлагын байрны барилга угсралт





**Төслийн нэр:**
Төв аймаг Сэргэлэн сум Бөхөг 15 МВт-ын НЦС анхдагч тоноглолын угсралт

**Захиалагч:** "М Си Эс Интернейшнл" ХХК

**Төслийн товч танилцуулга:**
Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах 15 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станцыг эрчим хүчний нэгдсэн системд холбох.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
110/10 кВ-ын 2x16МВА чадалтай дэд станцын анхдагч тоноглолын угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Төслийн нэр:**
Баруун-Урт дулааны станцын үнс зайлуулах систем

**Захиалагч:** Солонгосын Дулааны Шугам Сүлжээний Корпораци, Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

**Төслийн товч танилцуулга:**
Баруун Урт дулааны станц нь 13 Гкал/ц хүчин чадалтай бөгөөд КОИКА-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд Солонгосын Даесунг Глобал Нетворк, Дова Инженеринг, Солонгосын Дулааны Шугам Сүлжээ Корпораци 2013 онд барьж байгуулсан. Төслийн дараах үзлэг шалгалтыг КОИКА болон Солонгосын Дулааны Шугам Сүлжээ Корпораци хамтран хийсний дараа станцын үнс дамжуулах систем, галын усны систем, болон станцын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авахаар шийдсэн.








**Төслийн нэр:**
“НАРИЙН СУХАЙТ- БАЯНХӨНДИЙ 110КВ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, 2x16 МВА ДЭД СТАНЦЫН ТӨСӨЛ”-ийн хүрээнд төслийн “110/11кВ дэд станц, 11/0.4кВ-ын дэд станц, 11кВ ЦДАШ-ын угсралт суурилуулалт”

**Захиалагч:** “М Си Эс Интернэйшнл” ХХК

**Төслийн товч танилцуулга:**
110/11кВ дэд станц нь 2 үндсэн трансформатор, 2 секцээс бүрдсэн дэд станц юм. 110/11 кВ-н дэд станцаас “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ажилчдын амрах байр хүртэлх 7.8км ЦДАШ-ийг иж бүрэн угсран суурилуулна.

**Гүйцэтгэсэн ажил үүрэг:**
- Дэд станцын төмөр хийц, анхдагч хэлхээний тоног төхөөрөмжүүдийн угсралт суурилуулалт, туршилт тохируулга
- 11кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт, суурилуулалт
- 11/0.4 кВ-н 1000кВа станцын дэд өртөөний угсралт, суурилуулалт

**Төслийн нэр:**
“Өвөрхангай аймгийн төв Арвайхээр сумын 10-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах төсөл”-ийн тайлан

**Захиалагч:** Эрчим хүчний яам

**Төслийн товч танилцуулга:**
0.4кВ-ын ЦДАШ, 10кВ-ын ЦДАШ, 0.4кВ-ын ЦДКШ, Агаарын дэд өртөө зөөх, Гэр хорооллын айл өрхийн тоолууржуулалт, Орон сууцны айл өрхийн тоолууржуулалт, Аж ахуйн нэгжийн тоолууржуулалт, Хуучин орон сууцны дотор цахилгаан хангамж - Орон сууцны давхар хоорондын щит хайрцаг шинэчлэх, орц хоорондын ЦДКШ шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулах, Агаарын дэд өртөө, Трансформаторын чадлыг томсгох, Дэд станцын модон тулгуурыг солих зэрэг ажлуудыг төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.







RICHWELL
ENGINEERING LLC

# RICH IN KNOW HOW
# RICH IN SUCCESS

# РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТЖУУЛАЛТ



RICHWELL
ENGINEERING LLC

"Ричвелл Инженеринг" ХХК нь дэлхийн тэргүүлэх реле хамгаалалт, автоматжуулалт удирдлагын системүүдийг судалж шинэ технологиуд болон шийдлүүдийг салбар нэгжүүдэд амжилттай нэвтрүүлж байна.

Монгол улсын эрчим хүчний системд анх удаагаа 110кВ-ын агаарын шугамын 4 төгсгөлт дагуу дифференциал реле хамгаалалтын шийдлийг нэвтрүүлж АШ-109,110-д систем үүсгэгч 7 дэд станцыг хамруулан шугамын үндсэн хамгаалалт SEL-411L релег суурилуулж ажиллагаанд оруулсан.







NR Электрик компанийн реле хамгаалалт, автоматжуулалт, HMI программ, хяналт мэдээллийн СКАДА системийг ЦДҮС ТӨХК-ийн 110/10кВын 2*40МВА чадалтай “Шонхор” дэд станцад иж бүрнээр амжилттай нэвтрүүлсэн болно. NR Электрик компани нь дэлхийн эрчим хүчний систем дахь реле хамгаалалт автоматжуулалт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инженерчлэлийн салбарт 20 гаруй жилийн туршлагатай тэргүүлэгч компанийн нэг юм.



Бид NR Электрик компанийн реле хамгаалалт, автоматжуулалтын системийн бүтээгдэхүүн нийлүүлэлт угсралт, ашиглалтад оруулах туршилт болон засвар үйлчилгээ зэрэг бүх үйлчилгээг албан ёсоор үзүүлж байна.



Эрчим хүчний системд холбогдох томоохон чадлын цахилгаан цэнэгт хуримтлуурын систем, реактив чадлын компенсаторийн тооцоолол шийдэл боловсруулж, угсралт туршилт тохируула хийх үйлчилгээг нийлүүлэн ажиллаж байна.



RICHWELL
ENGINEERING LLC

*Rich in know how, rich in success*

(976) **11-311425**

**info@richwell.mn**

**www.richwell.mn**

Сити тауэр, 11 давхар 1103 тоот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо
Чингисийн талбай 5, Улаанбаатар хот, 14200, Монгол Улс